



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/10

Мандалговь

Ахмадад ээлтэй байгууллага, баг
шалгаруулж, шагнаж урамшуулах
тухай

Ахмад настны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3.4.2.1 дэх заалт, аймгийн Ахмад настны талаар 2018-2021 онд баримтлах бодлогын 6.6, Монгол улсын Сангийн сайдын 2018 оны тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 1 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Ахмадад ээлтэй байгууллага, баг"-ийн шалгуур үзүүлэлтийг хангасан аймгийн Онцгой байдлын газар, Өндөршил сумын Эрүүл мэндийн төв, Эрдэнэдалай сумын Эрүүл мэндийн төв, Сайнцагаан сумын Боржигон багийг 2020 оны "Ахмадад ээлтэй байгууллага, баг"-аар шалгаруулж тус бүрийг 200000 (Хоёр зуун мянга) төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

Хоёр. Шагналд зарцуулах 800000 (Найман зуун мянга) төгрөг, өргөмжлөл 200000 (Хоёр зуун мянга) төгрөг нийт 1000000 (Нэг сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Доржбат), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



481213019